


# MAZ-3115/24

Хэрэглэгчийн гарын авлага

24" LED HDTV/DVB-T2



Гэрэлтэн соёлтэйгээр туслаар тогтносон  
Малчид мандтугай!

Цагийн хязгааргүй цахилгаанаар хангана  
“Малчин” компани

## ГАРЧИГ

---

<b>Анхааруулга</b>	<b>1</b>
<b>Аюулгүй ажиллагааны зааварчилгаа</b>	<b>2</b>
<b>Дагалдах хэрэгслүүд ба Техникийн үзүүлэлт</b>	<b>3</b>
<b>Дагалдах хэрэгсэлүүд</b>	<b>3</b>
<b>Техникийн үзүүлэлт</b>	<b>3</b>
<b>Бүтээгдэхүүний танилцуулга</b>	<b>4</b>
<b>Холболтууд</b>	<b>5</b>
<b>Алсын удирдлага</b>	<b>6-7</b>
<b>Үндсэн үйлдлүүд</b>	<b>8</b>
<b>Дэлгэцийн Цэс</b>	<b>9-16</b>
1. Дүрсний тохиргоо	9
2. Дууны тохиргоо	10
3. Сувгийн тохиргоо	11-13
4. Нэмэлт тохиргоо	14-15
5. Системийн тохиргоо	16
<b>Кино, зураг үзэх заавар</b>	<b>17-22</b>
<b>Бичлэг хийх заавар</b>	<b>23</b>
<b>DVD тоглуулагчийн үйлдлүүд</b>	<b>24-30</b>
<b>Алдааг олж засварлах заавар</b>	<b>31</b>

## Анхааруулга

---



Энэхүү гурвалжин тэмдэг нь өндөр хүчдэл гэсэн утга илэрхийлэх бөгөөд тухайн хэсгийн хаалтыг онгойлговол цахилгаан гүйдэлд цохиулах аюултай.



Энэ гурвалжин тэмдэг нь техникийн үйлчилгээ (засвар) хийх болон онцгой чухал үйлдлүүд, цахилгаан барааны дагалдах бичиг баримтын хамт байгаа.



### **Бүтээгдэхүүний хаягдалыг зөв хаях**


(Цахилгаан болон Электрон барааны хаягдал (WEEE))

Таны хэрэглэж буй бүтээгдэхүүн сайн чанарын материал, эд ангиудаар хийгдсэн байдаг учир дахин ашиглах боломжтой юм.

Энэ тэмдэг нь цахилгаан болон цахим төхөөрөмжийг хаяхдаа ахуйн хаягдлаас тусдаа ялгаж хаяхыг илэрхийлж байдаг.

Тиймээс цахилгаан барааны хэрэглээ дуусч хаях үед орон нутгийн хаягдал цуглуулах төвд аваачиж өгнө үү!

Та хүрээлэн байгаа орчноо хамгаалах үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулна уу?



Уг бүтээгдэхүүн нь Европын цахилгаан хэрэгслийн аюулгүй байдал, цахилгааны нөлөөллийн стандартад нийцдэг.

## Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

---

Та доорхи аюулгүй ажиллагааны зааварчилгааг анхааралтай уншина уу.

Энэ нь бүтээгдэхүүний найдвартай ажиллагаа болон аюулгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлж өгнө.

---

### Цахилгааны Аюулгүй ажиллагаа

- Ачааллаас сэргийлэхийн тулд, нэг залгуурт хэт олон цахилгаан хэрэглэгчийг залгаж болохгүй.
  - Холбох утаснуудыг гишгэгдэх, эсвэл хөлд орооцолдох газарт тавьж болохгүй.
  - Хүнд зүйлсийг цахилгааны утсан дээр тавьж болохгүй.
  - Залгуураас салгахдаа утаснаас нь татаж болохгүй.
  - Аянга борооны үед эсвэл удаан хугацаагаар гадагш явахдаа антенаа салгах (хэрэв гадаа байрладаг бол), тогны үндсэн утсыг салгаж орхино.
  - ТВ рүү ус, чийг оруулж болохгүй. Чийгтэй орчин болох угаалгын өрөө, галт тогооны өрөө болон усан сангийн ойролцоо хэрэглэж болохгүй.
- Дараах тохиолдлуудад нэн даруй тогноос салгаж мэргэжилтэнд ханд:
  - Үндсэн залгуур болон утас гэмтсэн.
  - Санамсаргүйгээр ус юмуу өөр шингэн зүйл асгарч ТВ рүү нэвтэрсэн.
  - Санамаргүйгээр ямар нэг эд зүйл агааржуулалтын нүх рүү орсон.

**ТВ хэвийн ажиллахгүй үед:**

  - Дотор талд хэрэглэгч өөрөө үйлчилгээ хийх зүйлс байхгүй тул хамгаалах таг хайрцгийг нээж болохгүй. Нээвэл таны баталгаа хүчингүй болно. Зөвхөн мэргэжлийн хүмүүс энэ хэсэгт үйлчилгээ хийхийг зөвшөөрнө.
  - Зай гоожихоос сэргийлэхийн тулд удаан хугацаагаар хэрэглэхгүй үедээ эсвэл хугацаа дууссан зайг удирдлагаас авах хэрэгтэй.
  - Ашиглалтгүй болсон зайг задгай галын ойролцоо задалж болохгүй.

---


### Бүтээгдэхүүний аюулгүй ажиллагаа

- Арын хэсгийн агааржуулалтын нүхнүүдийг бөглөж болохгүй. Битүү тавиур дотор байрлуулахаар бол бүх талаасаа хамгийн багадаа 5 см зайтай байх ёстой.
- ТВ-н доторхи цахилгааны хэлхээг гэмтээж болзошгүй тул дэлгэцийг доргиож, цохихоос сэргийл. Мөн удирдлагыг норгох, алдаж унагахаас сэргийлж анхаарал болгоомжтой харьцах хэрэгтэй.
- ТВ-г арчихдаа зөөлөн хуурай даавуу хэрэглэх. Бензин болон бусад уусгагч агуулсан шингэн хэрэглэж болохгүй. Гүн тогтсон толбо, сэвийг арилгахын тулд шингэлсэн цэвэрлэгч бодисыг цэвэр алчуурт шингээн арчиж болно.

## Дагалдах хэрэгслүүд



Удирдлага  
E-37D



Хэрэглэгчийн гарын  
авлага



Хуруу зай



220 вольтын адаптер



Цахилгааны  
залгуур



12Вольт  
Автомашины залгуур



HDMI залгуур

\* Тэмдэглэл: Дагалдах хэрэгслүүд нь дээрх зурагт үзүүлсэнээс өөр байж болно.

## Техникийн үзүүлэлт


- ТВ-н систем	PAL SECAM BG/DK/I
- Дэлгэцийн өргөн	24 инч (диагональ)
- Нягтаршил	1920x1080
- Антены оролт	75 Ом (хэлбэлзэл)
- Дууны гаралтын хүч	2x3 Вт
- Эрчим хүчний хэрэглээ	9-24В 3А 36Вт

## Удирдлага

Төрөл	Хэт улаан туяа (IR)
Удирдах зай	5м
Удирдах өнцөг	30°

## Бүтээгдэхүүний танилцуулга

### Урдаас харсан байдал



**(IR)** Хэт улаан туяаны хүлээн авагч: Удирдлаганаас ирэх хэт улаан дохиог хүлээн авна.

LED гэрэл: **Асаах/унтраах**  товчин дээр дарах.

Гэрэл (Улаан)

Унтрах

Гэрэл (Ногоон)

Асаах

ТВ-н удирдлагын хамгийн оновчтой ажиллах зай нь удирдах цонхноос 5-8м байна.

**PLAY:** Дискийг Тоглуулах/түр зогсоох.

**EJECT:** Дискийг DVD тоглуулагчаас гаргах.

**SOURCE:** ОРОЛТ цэсийг харуулах.


**MENU:** Дэлгэцийн цэсийг Харуулах/Гарах.

**CH+/-:** Суваг өөрчлөх.

**VOL +/-:** Дууны хэмжээг тохируулах.

 : Асаах/унтраах

## Холболт



**VGA:** Компьютерийн дэлгэцийн залгуур. Компьютерийн VGA гаралт руу залгах аналог оролт

**PC-IN:** Компьютерийн дууны гаралтыг залгах оролт.

**Video:** видео төхөөрөмжийг залгах оролт.

**R/L in :** видео төхөөрөмжийн гаралтын дууг залгах оролт.

**RF:** Дижитал болон Аналог долгионы антенны оролт.

**COAX:** DTV коаксиаль гаралт.


**DDISH:** **DDISH хүлээн авагчийг DDISH гэсэн оролтонд холбоно.**

**USB:** Дуу, дүрс бичлэг хийх болон програмын нэмэлт суулгах USB оролт

**Headphone out:** Чихэвч болон бусад дууны төхөөрөмжүүдийг залгах гаралт.

**YPbPr:** Хөрвүүлэгч кабельтай DVD-ний гаралтыг залгах YPbPr видео оролт

**POWER:** 12В тэжээлийн утас холбох оролт



 **Power:** ТВ-г Асаах/Унтраах.

 **Дууг хаах товч:** Дууг буцаан нээхийн тулд Vol+ дарна.

### ТООТОЙ ТОВЧЛУУРУУД

Та ТВ үзэж байхдаа 0-9 хүртэлх товчин дээр даран сувгаа солж болно.

 Өмнөх суваг руу буцах товчлуур.

**INFO:** Таны үзэж буй ТВ-н болон дискний товч мэдээллийг харуулна.

**Өнгөт товч:** ТВ доторхи үндсэн цэс болон програмд харгалзах өнгийн товчнуудын гүйцэтгэх үүргийг текст байдлаар харуулах үүрэгтэй товчнууд.

**SOURCE:** ТВ-н оролтыг сонгоно.

**CH + /CH -:** Сувгуудыг солих

**VOL +/VOL -:** Дууны чанга сулыг тохируулах.

**EPG:** Дижитал ТВ Горимд дэлгэц дээр ТВ-н хөтөлбөр харуулна.

**P.MODE:** (Зургийн горим) Олон төрлийн дүрсний тохиргоонууд дарааллын дагуу гарч ирнэ.

**S.MODE:** (Дууны горим) Олон төрлийн дууны тохиргоонууд дарааллын дагуу гарч ирнэ.

**ASPECT:** Дэлгэцийн харагдах харьцааг өөрчилнө

**SLEEP:** Автоматаар унтрах цагийг тохируулна

**ЗААГЧ УДИРДАХ ТОВЧНУУД (▲/▼/◀/▶ OK/ENTER)**

Дэлгэцийн цэсийг удирдаж системийн тохиргоонуудыг өөрийн сонголтын дагуу өөрчлөх боломжийг танд олгоно.

**MENU:** Системийн тохиргооны цэс.

**EXIT:** Дэлгэцийн цэсээс гарах.



### DVD тоглуулагч.

**TV/RADIO:** Дижитал ТВ горимд Радио эсвэл ТВ-н аль нэгд шилжих

**FAV:** Дуртай хөтөлбөрийн жагсаалтыг харуулна.

**CH.LIST:** Сувгийн жагсаалтыг харуулна.

**REC:** Дижитал ТВ горимд бичлэг хийхийг эхлүүлэх товч

**SUBTITLE:** Дижитал ТВ горимд хадмал орчуулгыг харуулах/болих.

**REC.LIST:** Бичлэгийн жагсаалт.

**TV/TXT:** Дэлгэцийн бичмэл асаах/унтраах.

**CANCEL:** Дэлгэцийн бичмэл мэдээллийг цуцлах.

**REVEAL:** Ямар нэгэн нуусан текстийг харуулах.

**NICAM/A2:** ТВ-н NICAM/A2 горимын аль нэгийг сонгох.

**INDEX:** Индекс рүү очих.

**HOLD:** Одоогийн дэд хуудсыг зогсоох эсвэл гүйлгэх.

**SIZE:** Нэг дарвал хуудасны дээд талыг томруулж харуулна, дахин дарвал хуудасны доод талыг харуулна. Хэвийн хэмжээтэй болгохын тулд **SIZE** товчийг дахин дарах шаардлагатай.

**SUBPAGE:** Дэд хуудас руу орохын тулд нэг дарна, дахин дарвал цуцална.

- ▲ : Дискийг DVD тоглуулагчаас гаргах
- : Хөтөлбөрийг зогсоох
- ▶▶ : Хөтөлбөрийг тоглуулах/түр зогсоох.
- ◀◀ : Буцааж гүйлгэх.
- ▶▶ : Урагш гүйлгэх.
- ◀◀ : Өмнөх бүлэг рүү буцах.
- ▶▶ : Дараагийн бүлгийг тоглуулах.

**D.SET:** DVD системийн тохиргоо

**D.MENU:** Дискний цэс, бичлэгүүдийн дараалал

**D.SUB:** DVD –н хадмал орчуулга хаах/нээх

**D.LAN:** DVD –н хэлийг солих (хэрэв боломжтой бол)

## Үндсэн үйлдлүүд

### Асаах/Унтраах

1. Адаптороор дамжуулан цахилгаан үүсгүүрт холбох.
2. ТВ-ын Асаах/Унтраах  товч

### Оролтын үүсгүүрийг сонгох

ТВ эсвэл удирдлага дээрх **SOURCE** (оролтын үүсгүүр) товчлуурыг дарж сонгох цэсийг гаргаж ирнэ. ТВ-н CH+/- товчлуур эсвэл удирдлага дээрх ▲/▼ товчлуурыг дарж оролтын үүсгүүрийг сонгоно. Хэрэв **DDISH** үзэх гэж байгаа бол **DDISH** гэсэн сонголтыг хийнэ. Удирдлагын ОК товчлуурыг дарж сонгосон оролтын хөтөлбөр эсвэл бичлэгийг үзнэ.

**Тэмдэглэл:** **SOURCE**(оролтын үүсгүүр) *сонгохоос өмнө холболтууд бэлэн болсон эсэхийг нягтал!*



### Дэлгэцийн цэсний үндсэн ажиллагаа

**Цэс** товчлуурыг дарвал доор үзүүлсэн дэлгэцийн цэс гарч ирнэ.

Үндсэн Цэс: Дүрс Дуу Суваг Нэмэлт Систем



Дүрсний Горим	Хэрэглэгчийн
Цайралт	50
Ялгарал	50
Тодрол	5
Туяа	50
Өнгөний хэм	Стандарт
Дэлгэцийн харьцаа	Дүүрэн

Шилжих   Ок   Нэвтрэх   Exit   Гаргах   Мени   Буцах

**Дэд цэс**  
(Жишээ нь:  
"Дүрс" дэд цэс)

**Санамж:** Дэлгэцийн цэстэй ажиллахдаа ашиглана.

Үндсэн цэс дотор ▲/▼ товчлуур ашиглан дэд цэсээ сонгоод ОК товчлуур дарж дэд цэс рүү нэвтэрнэ. Дэд цэс дотроо ▲/▼ товчлуур ашиглан хийх үйлдлээ сонгоод ОК дарж тохиргооны хэсэгт нэвтэрнэ. Дараа нь ◀/▶ товчлуураар тохиргоогоо өөрчлөөд ОК дарах эсвэл ▲/▼ товчлуураар өөр дэд цэсэнд шилжиж тохиргоогоо хадгална.

- **MENU** товчлуур дарвал дээд түвшний цэсэнд шилжиж орно.
- **EXIT** товчлуур дарвал дэлгэцийн цэснээс бүр мөсөн гарна.

### Тэмдэглэл:

**а) Мени нь түүнд тохирох SOURCE (оролтын үүсгүүр)-тэй холбогдож дохио хүлээн авч байгаа тохиолдолд л идэвхжсэн байна**

**б) Мени-тай ажиллахдаа сурталчилгааны доор байрлах сануулгын дагуу ажилла.**

## Дэлгэцийн цэс

### 1. “Дүрс” цэс



### Тайлбар

**Дүрсний Горим:** Динамик, Стандарт, Дундаж болон Хэрэглэгчийн гэсэн дүрсний горимуудаас тохирох горимоо сонгоно.

**Цайралт:** Дүрсний цайралтын түвшинг тохируулна.

**Ялгарал:** Дүрсний өнгөний ялгарлыг тохируулна.

**Тодрол\*:** Өнгөний тодролыг тохируулна (VGA/PC горимд ажиллахгүй).

**Өнгө:** Хараас цагааны хооронд өнгийн тохиргоо хийнэ.

**Туяа:** NTSC горимд өнгөний хослол тохируулна.

**Өнгөний хэм:** Халуун, Хүйтэн, Стандарт.

**Дэлгэцийн харьцаа:** Дэлгэцийн харьцааг 4:3, 16:9, Томруулах1, Томруулах2 эсвэл Панорам г.м сонголтоос сонгож тааруулна.

**Шуугиан бууруулах:** Хэрвээ хүлээн авч буй дохио сул байвал “Шуугиан Бууруулах” цэснээс “Унтраах”, “Бага”, “Дунд” болон “Өндөр” гэдгийн аль тохирохыг сонгож үзнэ.

## Дэлгэцийн цэс

### 2. “Дуу” цэс



#### Тайлбар

**Дууны горим:** Өөрт таалагдах дууны горимыг Стандарт, Кино, Хөгжим, Яриа болон Хэрэглэгчийн гэсэн жагсаалтаас сонгоно.

**Аргил:** Нам давтамжийн дууны түвшинг тохируулна.

**Нарийн:** Өндөр давтамжийн дууны түвшинг тохируулна.

**Тэнцвэр:** Дууны гаралтын баруун зүүн талын дуугаралтыг тохируулна.

**Бодит дууны дугаралт:** Бодит дууны дугаралтыг **Асаах/Унтраах** боломжтой.

**Автомат Дууны Түвшин (AVL):** Энэ функцийг идэвхжүүлсэн тохиолдолд бүх эх сурвалжын дуугаралтыг ТВ өөрөө тохируулна.

**Дууны тохиргоо:** дижитал дууны гаралтыг тохируулах

## Дэлгэцийн цэс

### 3. “Суваг” цэс (Аналог ТВ/Дижитал ТВ горимд)



### Тайлбар



**Сувгийн Удирдлага:** Сувгуудыг удирдахын тулд энэ цэсэнд орно.

**Арилгах:** Арилгахыг хүсэж байгаа сувгаа сонгоод **УЛААН** товчлуур дарна.

**Цоож:** Та энэ функцыг хэрэглэхийн тулд “Цоож идэвхжүүлэх” гэдгийг (Нэмэлт-Цоож-Цоож идэвхжүүлэх) ON болгох ёстой. **“НОГООН”** товчлуурыг дарж цоожлох эсвэл цоожийг тайлах сувгаа сонгоно. Үүний дараа нэвтрүүлгийг үзэх нууц үгийг хийнэ.

**Алгасах:** **“ШАР”** товчлуур дарж алгасах сувгийг сонгох эсвэл энэ тохиргоог цуцалж болно. Алгасах үйлдлийг идэвхжүүлсэн суваг удирдлагын CH+/- товчлуурт орохгүй.

**Зөөх:** **“Цэнхэр”** товчлуур дарж зөөх сувгаа идэвхжүүлнэ. Дараа нь удирдлага дээрх ▲/▼ товчлуурыг дарж зөөгөөд “OK” дарж бататгана.

## Дэлгэцийн цэс

**Дуртай сувгууд:** Өнгөт товчлуурууд ашиглан дуртай сувгийн жагсаалтаа нэмж хасч болно. 4 хүртэл тооны жагсаалт үүсгэх боломжтой. Үүнд:  
**УЛААН Д-1, НОГООН Д-2,  
ШАР Д-3, ЦЭНХЭР Д-4.**

No.	Хөтөлбөрийн нэр	Д-1	Д-2	Д-3	Д-4	
0003	CBBC Channel					dtv
0004	BBC TWO					dtv
0005	ANTENA 3					dtv
0006	ANTENA.NEOX					dtv
0007	ANTENA.NOVA					dtv
0008	GOL TELEVISIÓN					dtv
0001	ONDA CERO					radio
0002	EUROPA FM					radio
0003	ONDA MELCENIA					radio

**Улс:** Улсаа сонго.

*“Хүүхдээс Хамгаалах” үйлдлийг идэвхжүүлсэн бол автомат болон гар суваг хайлт үйлдлийг эхлүүлэхийн тулд ашиглах нууц үг хийнэ үү. (Нэмэлт цэсний Нууц үгийн Цоож)*

**Автомат Хайлт:** цэсэнд орохын тулд ОК дараад, хайлт хийх горимоо сонгоно. Хайлтыг эхлүүлэхийн тулд ОК товчлуурыг дахин дарна.



Тэмдэглэл:

1. **Бүгд:** Дижитал суваг, Аналог суваг болон радиог автоматаар хайна.  
**Дижитал ТВ:** Дижитал суваг ба Радиог автоматаар хайна.  
**Аналог ТВ:** Аналог сувагуудыг автоматаар хайна.
2. Автоматаар суваг хайж байгаа үед удирдлага дээрх “MENU” товчлуурыг дарж хайлтыг шууд зогсоон өмнөх цэсэнд шилжин орно.

**Дижитал ТВ Гар хайлт:** Дижитал ТВ Гар хайлт цэсэнд орно.

ТВ-н удирдлагын ▲/▼ товчлуураар дээш доош гүйлгэн ◀/▶ сувгаа сонгоно. Дараа нь ▲/▼ товчлуур дарж “Эхлүүлэх” дээр аваачин ◀/▶ товчлуур дарж гар хайлтыг эхлүүлнэ.



**DVB-T2**

## Дэлгэцийн цэс

Аналог ТВ Гар хайлт: Аналог ТВ Гар хайлт цэсэнд орно.



**Одоогийн Суваг:** Гар хайлт хийх Одоогийн Сувгаа сонгож авна.


**Хайлт:** ОК товчлуур даран Хайлт цэсэнд орж ◀/▶ товчлуур ашиглан гараар тохирох давтамжийг хайна.

**Нарийвчилсан Хайлт:** ОК товчлуур даран Нарийвчилсан Хайлт цэсэнд орно. ◀/▶ товчлуур ашиглан нарийвчилсан хайлтыг эхлүүлнэ.

**Өнгө/Дууны систем:** Хөтөлбөрт тохирох Өнгө/Дууны системийг сонгоно.

## Дэлгэцийн цэс

### 4. Нэмэлт цэс



### Тайлбар



**Цоож:** Энэ цэс нь ТВ-н зарим нэг онцлог зүйлсийг ашиглахгүй, үзэхгүй байхаар цоожлоход хэрэглэгдэнэ. Таныг системийн цоож цэсэнд нэвтрэнгүүт нууц үг асуух ба үйлдвэрийн тохиргоогоор анх "0000" байдаг.

**Цоожийг Идэвхжүүлэх:** Цоожлох үйлдлийг On/Off (Идэвхтэй/Идэвхгүй) болгоно. Тэмдэглэл: Энэ функцыг идэвхжүүлэнгүүт доорх "Эцэг Эхийн Хяналт" болон "Пин Код Солих" функцууд цоожлогддо. Мөн түүнчлэн "Суваг" цэсэнд байрлах "Функцын Цоож", "Автомат Хайлт", "Дижитал ТВ Гар Хайлт", "Аналог ТВ Гар Хайлт" цэснүүд цоожлогдоно.

**Эцэг Эхийн Хяналт:** Эцэг Эхийн Хяналт горимыг идэвхжүүлэх эсвэл идэвхгүй болгох.  
**Пин Код Солих:** ОК товчлуур дарж орно. Эхлээд одоо ашиглаж байгаа кодоо оруулна. Дараа нь шинэ кодаа оруулаад дахин хийж баталгаажуулна.

## Дэлгэцийн цэс

---

**Хэл:** Боломжит хэлнээс сонголт хийнэ.

**Цаг:** Цагийг тохируулна. (Дижитал антенна холбогдсон бол цаг автоматаар тохируулагдана)

**Унтрах цаг:** Автомаар унтрах хугацааг тохируулсна.

**Автоматаар унрах:** ТВ нь тохируулсан хугацааны туршид ямар нэг үйлдэл хийгдэхгүй бол автоматаар унтрах горим. Та 1, 2, 4цаг эсвэл болиулах гэсэн сонголтоос сонгоно.

**Сонголын бэрхшээлтэй:** Энэ цэсийг идэвхжүүлснээр тухайн суваг боломжтой бол нэмэлт мэдээлэл болон хадмал орчуулгыг гаргана.

**Бичлэг хийх/нөхөж үзэх:** Дэлгэрэнгүй мэдээллийг БИЧЛЭГ ХИЙХ ҮЙЛДЭЛ цэснээс үзнэ үү.

## Дэлгэцийн цэс

### 5. Тохиргоо цэс



#### Тайлбар

**Дэлгэцийн цэсний хугацаа:** Дэлгэц дээр харагдаж байгаа цэс тодорхой хугацааны дараа алга болохыг тохируулна.

**Компьютерийн тохиргоо:** Компьютер горимын тохиргоо хийнэ.



**Автомат тохируулга:** Дэлгэцийн хэмжигдхүүнүүдийг автоматаар тохируулна

**X/B-Байрлал:** Дэлгэцийн Хөндлөн/Босоо байрлалыг тохируулна.

**Фаз:** Дүрсийг тогтвортой болтол синхрончлох дохиог тохируулна.

**Цаг:** Дэлгэц дээрх дүрс хамгийн том болтол давтамжийн тохиргоог өөрчилнө.

**Цэнхэр дэлгэц:** Ямар нэг дүрсний дохио байхгүй үед харагдах хоосон цэнхэр дэлгэцийг өөрчлөх боломжтой (зарим нэг эх сурвалжийн хувьд л боломжтой).

**ТВ-н тохируулгыг шинэчлэх:** Энэ нь өмнө тохируулсан ТВ-н бүх тохиргоог өөрчилж үйлдвэрээс ирсэн байдлаар шинэчилнэ.

**Програм шинэчлэх:** Програм шинэчлэх цэс

## Мультмедиа үйлдэл

### Үндсэн Үйлдлүүд

1) ТВ-н удирдлагын “SOURCE” товчлуурыг дарж “Оролт” цэсийг гаргана. SOURCE ▲/▼ товчлуур ашиглан сонгож ОК товчлуур даран Мультмедиа цэсэнд орно.



2) USB-г ТВ-т залган Зураг, Хөгжим, Кино болон Электрон ном гэсэн горимоос сонголтоо хийнэ. Ингэснээр доорхи дэлгэцэнд үзүүлсэнтэй адил сонголт гарч ирнэ.



Хийж болох  
үйлдлийн сануулга

## Мультмедиа үйлдэл

### Үндсэн Үйлдлүүд

3) Энэ ▲/▼ товчлуурыг ашиглан USB төхөөрөмжөө сонгоод ОК товчлуур дарж доор үзүүлсний адил файлын жагсаалтаа харна.



Энэ ▲/▼ товчлууруудыг ашиглан шилжинэ (ОК товчлуураар файл сонгох эсвэл хавтасыг нээнэ).

**УЛААН** товчлуур дарж файлыг арилгана.

**НОГООН** товчлуур дарж бүх файлыг жагсаалтад нэмэхээр сонгох эсвэл болих үйлдэл хийнэ.

**ОК** товчлуур дарж сонгогдсон файлуудыг оруулах эсвэл болих үйлдэл хийнэ.

◀ товчлуур дарж өмнөх цэс рүү буцна.

**EXIT** товчлуур дарж файл сонгох харагдах байдал, төрлийн жагсаалт (◀) эсвэл жижигрүүлж харах (▶) байдалд шилжинэ.

**EXIT** товчлуурыг дахин дарвал Үндсэн Цэс-д эргэж очно.

Дараа нь ▶ товчлуурыг дарж таны сонгосон хавтас дахь файл эсвэл хөтөлбөрийг тоглуулна.

Зогсоохын тулд ■ товчлуур дарж бүтэн дэлгэцнээс гарна. Дэлгэцийн доод хэсэгт байрлах сануулгуудыг харна уу.

## Мультмедиа үйлдэл

### 1. Фото

Фото зураг тоглуулах



◀/▶ товчлуур ашиглан үйлдлээ сонгоно, ОК товчлуур дээр даран үйлдлийг дуусгана.

Тэмдэглэл: Хэрвээ үйлдлийн товчлуурууд харагдахгүй бол ОК товчлуур дарж гаргаж ирнэ.

▶/|| Зураг тоглуулах үйлдлийн Тоглуулах/Түр зогсоох.

■ Зогсоож бүтэн дэлгэцийн горимоос гарна.

|◀▶| Өмнөх ба дараагийн файлыг шууд тоглуулна.

↻ Зургийг эргүүлнэ (эргүүлэх өнцөг 0, 90, 180, 270).

🔍 Зургийг томруулж/жижигрүүлж харуулна. Энэ горимд курсор ашиглан зургаа зүүн/баруун/дээш/ доош хөдөлгөнө.

ℹ Одоо үзэж байгаа зургийн файлын тухай мэдээлэл харуулна.

⚙ Фото тохируулах цэсийг харуулна. Үүнд: Давтах горим, Ая, Зураг солигдох хугацаа,

☰ Эффект. Тоглуулж буй файлуудын жагсаалт харуулна.

### 2. Хөгжим, дуу

Хөгжим, дуу тоглуулах



◀/▶ товчлуур ашиглан үйлдлээ сонгоно, ОК товчлуур дээр даран үйлдлийг дуусгана.

▶/|| Сонгосон хөгжим, дууг Тоглуулах/Түр зогсоох

■ Тоглуулж байгаа дуу хөгжимийг зогсоож гарна.

◀▶ Урагш, хойш нь хурдан гүйлгэх.

|◀▶| Өмнөх болох дараагийн файлыг шууд тоглуулах.

ALL Тоглуулж байгаа хөгжмийн давтах горимыг сонгох.

📄 "Мэдээлэл" ба "Жагсаалт" цонхнуудын хооронд шилжих.

☒ Хөгжим тоглож байхад дэлгэцийг Нээх/Хаах горимд шилжих.

## Мультмедиа үйлдэл

### 3. Кино

Кино тоглуулах



◀/▶ товчлуур ашиглан үйлдлээ сонгоно, ОК товчлуур дээр даран үйлдлийг дуусгана. Тэмдэглэл: Хэрэв үйлдлийн товчлуурууд харагдахгүй бол ОК товчлуур дарж гаргана.

- ▶/|| Сонгосон киног Тоглуулах/Түр зогсоох.
- Тоглуулж байгаа киног зогсоож бүтэн дэлгэцээс гарах.
- ◀◀▶▶ Урагш хойш нь хурдан гүйлгэх.
- ▶ Киног удаашруулж тоглуулах.
- ▶| Киног алхам алхамаар алгасуулж тоглуулах.
- ↺↻ АВ А-В давтаж тоглох горимд тохируулах.
- ◀▶| Өмнөх ба дараах киног шууд тоглуулах.
- ☰ Тоглуулж буй кинонуудын жагсаалтыг харуулах.
- ⓘ Одоо тоглуулж байгаа киноны файлын харуулна.
- ⚙ Кино тохиргооны цэс харуулах Тоглуулагч програм, Хадмал орчуулга, Дуу, Давтах горим зэргийг тохируулна.
- 🕒 Алгасах горим. Хугацааны өгөгдлөө оруулан тухайн хугацаанаас шууд тоглуулна.

### 4. Цахим ном

Цахим ном унших.



- ◀◀▶▶ Номын өмнөх/дараах хуудсыг эргүүлнэ.
- УЛААН** товчлуур: Номын хавчуурга оруулах эсвэл арилгах.
- НОГООН** товчлуур: Хавчуурга бүхий хуудсыг нээх.
- ШАР** товчлуур: Хавчуурга бүхий хуудсуудын жагсаалт харуулах.
- ЦЭНХЭР** товчлуур: Цахим номуудын жагсаалт харуулах.

## Бичлэг хийх үйлдэл

### Бичлэг хийх тохиргоо


ЦЭС товч дээр даран “Онцлог-Бичлэг хийх/Нөхөж үзэх” цэсийг сонгоно. ОК товч дээр даран доор үзүүлсэн цэс рүү орно.



#### 1) Бичлэг хийх файлын төрөл

USB төхөөрөмж рүү бичлэг хийж хадгалах файлын төрлийг TS эсвэл PS горимын аль нэгээр сонгоно.

#### 2) Хуваалтыг сонгох



USB төхөөрөмжийн мэдээлэл

**Форматлах: УЛААН** товч дээр дарж сонгосон USB төхөөрөмжийг форматлана.

**Өгөгдмөл хуваалтыг заах: НОГООН** товч дээр даран сонгосон хуваалтыг зааж өгнө. Бичигч нь өгөгдмөл хуваалтад бичлэгийг хадгална. Хэрэв бичлэг хийх явцад өгөгдмөл хуваалт дүүрвэл түүнийг дахин шинээр зааж өгөх хэрэгтэй.

#### 3) Ухрааж үзэх буфер


Ухрааж үзэх буфер горимыг: Автомат, 30 минут, 1 цаг, 2 цаг гэж тохируулж болно.

#### 4) Цагийн тоолуур

Цагийн тохиргоо цэсэнд орж бичлэгийн цаг тоолуурыг тохируулна.



Нэмэх **ШАР** товч дээр дарна



**Бичигч: Бичлэгийн асаах/унтраах функц**

**Төрөл:** Бичиж авахыг хүсч буй хөтөлбөрийн төрлийг сонгоно.

**Суваг:** Бичиж авахыг хүсч буй сувгийг сонгоно.

**Эхлэх хугацаа:** Бичлэг хийх хөтөлбөрийнхөө эхлэх хугацааг тохируулна.

**Үргэлжлэх хугацаа:** Бичлэгийн үргэлжлэх хугацааг тохируулна.

**Өдөр:** Бичлэг хийх өдрийг сонгоно.

**Горим:** Бичлэгийн горимыг сонгоно.

## Бичлэг хийх үйлдэл

### 5) Бичлэгийн жагсаалт

Бичлэгийн жагсаалт цэсийг дэлгэц дээр гаргана.



**Арилгах:** УЛААН товчин дээр даран сонгогдсон бичлэг хийх төлөвлөгөөг устгана.

### 6) Бичлэг эхлүүлэх

Удирдлаганы **REC** товч дээр даран бичлэг хийх функцийг идэвхжүүлнэ. Үүний дараа **OK** товчийг сонгосноор бичлэгийг эхлүүлнэ.

### ТВ-ын хөтөлбөр (EPG) болон бичлэгийн цаг тоолуур

Удирдлаганы **EPG** товчин дээр даран дэлгэцийн EPG цэс рүү нэвтэрнэ.



**EPG Горим:** УЛААН товчин дээр дарахад дэлгэцийн EPG горим өөрчлөгдөнө.

**Өдөр тутмын горим:** Өдөр тутам цацагдаж буй ТВ-ын хөтөлбөрийг үзүүлдэг горим юм.

**Долоо хоногийн горим:** Долоо хоног бүр цацагдаж буй ТВ-ын хөтөлбөрийн үзүүлдэг горим юм.

**Сануулга:** Үзэх хөтөлбөрөө сануулахын тулд **НОГООН** товч дээр дарна. Бичлэг хийхийн тулд **НОГООН** товч дээр дахин нэг дарах хэрэгтэй. Цагийн тоолуур цэсэнд орж шалгахад бичлэг хийх хуваарь орсон байна. Ингэснээр ТВ-ын хөтөлбөр автоматаар бичигдэнэ.

**Өмнөх/Дараах өдөр:** ШАР/ЦЭНХЭР товчин дээр дарснаар өмнөх болон дараагийн хөтөлбөрүүд дэлгэц дээр гарч ирнэ.

## Бичлэг хийх

Дижитал ТВ горимд бичлэг хийхийн тулд ТВ-н удирдлага дээрх **REC** товчлуурыг дарахад танд сануулга мэдээлэл гаргаж үзүүлнэ. Дэлгэц дээрх **ТИЙМ** бичгийг сонгож удирдлага дээрх **OK** товчлуур дарахад дэлгэц дээр бичлэг хийж байгаа тэмдэг гарч харагдана.



Тэмдэглэл:

- 1) Бичлэг хадгалах **USB** төхөөрөмжийг ТВ-д залгасан эсэхийг шалгана уу.
- 2) **USB** төхөөрөмжийн сул зайтай болон хурд нь бичлэг хийхэд хангалттай эсэхийг шалгана уу.
- 3) Бичлэг хийх горимоос гарахын тулд **STOP** товчлуур дарна
- 4) Бичлэгийн жагсаалт товчлуураг дарж бичигчийн жагсаалтыг харах ба үзэх хөтөлбөрөө сонгон бичлэгээ тоглуулж болно
- 5) Түүнчлэн бичиж авсан хөтөлбөрөө Мультимедиа горимоор орж тоглуулж болно.

## Нөхөж үзэх

ТВ-н удирдлага дээрх **II PAUSE** товчлуур дарж Дижитал ТВ горимд нэвтрүүлэг нөхөж үзэх үйлдлийг эхлүүлнэ. Энэ үед дэлгэц дээр сануулга гарч ирнэ. Дэлгэц дээрх **ТИЙМ** бичгийг сонгож удирдлага дээрх **OK** товчлуур дарснаар дэлгэц дээрх дүрс хөдөлгөөнгүй болж нөхөж үзэх үйлдэл эхэлснийг илтгэх тэмдэг гарч ирнэ.



Тэмдэглэл:

- 1) Бичлэг хадгалах **USB** төхөөрөмжийг ТВ-д залгасан эсэхийг шалгана уу.
- 2) **USB** төхөөрөмжийн сул зайг шалгана уу
- 3) Нэвтрүүлэг ухраах горимоос гарахын тулд **STOP** товчлуур дарна
- 4) **PLAY** товчлуурыг дарж бичиж буй нэвтрүүлгийг эхнээс нь үзэж болох ба нэвтрүүлэг бүрэн бичигдэж дуусах хүртэл ухраах үйлдэл явагдана.
- 5) Дэлгэцийн баруун дээд буланд байрлах “Нэвтрүүлэг Нөхөж үзэх цаг” цэсэнд одоо явж байгаа нэвтрүүлэг болон бодит цаг хугацааны нэвтрүүлэг хоорондын зөрүү харагдана.
- 6) Хэрэв бичлэг хийж байгаа үед дохио алдагдвал дохиог дахин тогтвортой орж иртэл бичлэг хийхгүй түр хүлээнэ.

## DVD тоглуулагчийн үйлдлүүд

### Ерөнхий үйлдлүүд

ТВ эсвэл Удирдлаганы **Source** товчийг дарж **DVD** горимыг сонгоно.

Хэрвээ **DVD** тоглуулагчид диск байхгүй бол дэлгэцэн дээр “Диск байхгүй байна” гэсэн бичиг гарна. Дискайг хийхдээ тоглуулагч дээрх зааврын даруу дискээ байрлуулж хийнэ. Дискний толин хэсэгт гараар хүрч болохгүй.

Дискайг хуруугаараа гадна тойрог талаас барин тоглуулагчид хийхэд тоглуулагч автоматаар дискайг татан авна. Араас нь хүчээр түлхэж хийхийг хориглоно.

ТВ –н **EJECT** товч болон Удирдлаганы “\_” товчийг дарж дискайг гаргаж авна.

DVD тохируулганы горим

- Тохируулганы цэс нь Ерөнхий тохиргоо, Дууны тохиргоо, Долби дуу тоон тохиргоо, Тохируулга, Сонголтын хуудас гэсэн цэснүүдээс бүрдэнэ.
- Тохируулгыг хийхдээ чиглэлийн сум, SETUP, ОК товчнуудыг тусламжтай гүйцэтгэнэ.
- SETUP товчийг дарж үндсэн цэсрүү орж > товчийг дарж дэд цэсрүү шилжинэ.
- SETUP товчийг дахин дарж цэснээс гарна.

## Ерөнхий цэс

ТВ –н дэлгэц

### 4:3 Шууд харуулах

DVD тоглуулагч энгийн ТВ-д холбогдсон үед сонгоно. Өргөн дэлгэцийн бичлэгийн зарим дэлгэцэнд багтахгүй хэсэг хасагдаж харагдана

### 4:3 Шахсан

DVD тоглуулагч энгийн ТВ-д холбогдсон үед сонгоно. Өргөн дэлгэцийн бичлэгийн дээд, доод хэсэгт дүрсгүй харлаж харагдана.

### Өргөн

DVD тоглуулагч өргөн дэлгэцтэй ТВ-д холбогдсон үед сонгоно.



## DVD тоглуулагчийн үйлдлүүд

### Цэсний хэл

Цэсний хэлийг боломжит хэлнээс сонгоно.



### Дэлгэц амраагч

Дэлгэц амраагч нь тоглуулагч зогссон эсвэл дүрс хөдөлгөөнгүй хэсэг хугацаа өнгөрсний дараа ажиллана. Энэ нь таны дэлгэцийг гэмтэхээс сэргийлнэ.

- Асаах
- Унтраах




### Сүүлд санасан

- Нээх (унтраах үеийн тохируулга хадгалагдана)
- Хаах (Тоглуулагч унтраад асах болгондоо үйлдвэрийн тохиргоог ачааллана)



### Дууны тохируулга




#### Чанга яригчийн тохируулга

Дууны тохируулга дээр “▼” товчийг дарж Чанга яригчийн сонголтийг хийнэ, “OK” эсвэл “▶” товчийг дарж Дууны тохируулгаруу орно

#### Стерио


- LT/RT
- Стерио п



## Долби дуу тоон тохиргоо

### Динамик

Дууны ялгаралыг удирдах үүднээс шахалтын харьцааг тохируулна.



## Сонголтын хуудас

**STOP** товчийг 2 удаа дарж Сонголтын хуудасруу орно


**ТВ –н төрөл**

- PAL
- MULTI
- NTSC




## Дуу

Хэрэв дискэн дээр олон төрлийн хэлийг давхар бичиж өгсөн бол энэ цэснээс хэлийг сонгох боломжтой




## Хадмал оруулга

Хэрэв дискэн дээр олон төрлийн хэлний хадмал орчуулгыг давхар бичиж өгсөн бол энэ цэснээс хадмал орчуулгын хэлийг сонгох боломжтой



## Дискний цэс

Хэрэв дискэн дээр олон төрлийн хэлний цэс давхар бичиж өгсөн бол энэ цэснээс хэлийг сонгох боломжтой



## Эцэг эхийн

Хэрэв 13+ сонгогдсон бол түүнээс доош зэрэглэлтэй диск уншигдахгүй гэсэн үг

- Хүүхдийн
- Бүх насны
- Хяналтан дор
- 13+
- Заавал хяналттай
- 16+
- 17+
- Насанд хүрсэн



## Нууц үг


Та нууц үгийг сольж болох бөгөөд үйлдвэрээс тохируулсан нууц үг нь "123456"





## Цаанаас сонгосон

Үйлдвэрийн тохиргоонд эргэн оруулах, дахин ачааллах



## Техникийн үйлчилгээ ба ашиглалт

---

### Энгийн гэмтлийг илрүүлж засварлах

Хэрвээ дэлгэц нээгдэхгүй эсвэл үйл ажиллагаа нь илэрхий муу байвал дараах зааврын дагуу шалгаж үз. Эхлээд холбогдох төхөөрөмжүүд нь зурагтын зөв оролтод гүйцэд холбогдсон эсэхийг шалгана. Хэрвээ дэлгэц урьдын хэвээр нээгдэхгүй байвал худалдан авсан газартайгаа холбоо барих хэрэгтэй.

### Тэжээл байхгүй

- Зурагт руу орсон бүх холболтыг шалга.
- Зурагтын удирдлага дээрх **Power** товчлууур болон **Standby** товчлууруудыг дарж үз.

### Дуу болон дүрс байхгүй байх

- Зурагтаа цахилгаанд залгаад асаах товчлууур дарсан эсэхээ дахин шалга.
- Антенна гүйцэд зөв холбогдсон байгаа эсэхийг шалга.
- Өөр суваг, эсвэл өөр эх сурвалжаар нэвтрүүлэг, бичлэг тавьж үзэх.

### Дүрсний чанар муу байх

- Антенна гүйцэд зөв холбогдсон байгаа эсэхийг шалга.
- Сувгаа зөв тааруулсан эсэхийг шалга, дахин шинээр хайлга.
- Дүрсний тохиргоог өөрчилж үз: Цайралт, Өнгө, Тодрол, Ялгарал, Дэвсгэр өнгө г.м.
- Танай зурагт өөр ямар нэг радио давтамжийн шуугиан үүсгэж болох цахилгаан хэрэгсэл, төхөөрөмж зэргийн дэргэд байрласан эсэхийг шалга.

### Өнгө байхгүй

- Өнгөний тохиргоог өөрчилж үзэх.
- Тухайн нэвтрүүлэг өнгөтөөр дамжуулагдаж байгаа эсэхийг шалга, суваг сольж үз.
- Сувгаа зөв тааруулсан эсэхийг шалга, дахин шинээр хайх.

### Зурагт алсын удирдлагаар удирдагдахгүй байх

- Зурагт болон удирдлагын хооронд ямар нэг саад болох зүйл байгаа эсэхийг шалга.
- Удирдлага ба зурагт хоёрын дундах зай удирдах хэмжээнд байгаа эсэхийг шалга.
- Удирдлагын батарейн цэнэг бага, шингэн гоожсон, хугацаа дууссан эсэхийг шалга.

Энэ зурагт нь ахуйн хэрэглээнд зориулагдсан, цахилгаан соронзон долгионы нөлөөлөл аюулгүй гэж бүртгэгдсэн тул гэртээ болон өөр хаана ч ашиглах боломжтой.

Идэр есийн хүйтэнд улам гялалздаг  
Чин Зоригт малчид мандпуугай!

Цагийн хязгааргүй цахилгаанаар хангана

“Малчин” компани

# MAZ-3115/24



## 24" LED HDTV/DVB-T2



“Malchin Group”

Bayanzurkh district 25 khoroo, Narny zam-20 P.O.box 305

Ulaanbaatar, 13373, Mongolia

Tel: 976-70153115

Fax: 976-70153115

Email: [contact@malchingroup.mn](mailto:contact@malchingroup.mn)

Web: [www.malchingroup.mn](http://www.malchingroup.mn)